

СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
Бүртгэлийн дугаар: 45
ХҮҮЛБАР ҮНЭН
Х.Б.П.Х.О. Хамгийн дунд
(Албан тушаалын нэр)
Х.Б.П.Х.О. Хамгийн дунд
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)
2024 оны 04-р сарын 08 ны өдөр.

МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ
127-00073
ТУ32326 9051449

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 04 сарын 25-ны
өдрийн 6774 дугаарт бүртгэв.

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/19

Баруун-Урт сум

Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх,
цагийн хуваарийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.5, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газруудын согтууруулах ундаа, худалдах, үйлчлэх цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Монгол Улсын Их Хурлын, Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах өдөр, санал авах өдрийн өмнөх болон дараагийн өдөр аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг хориглосугай.

3. Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сар бүрийн 01-ний өдөр аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдахыг хориглосугай.

4. Захирамжийг холбогдох хууль, журмын дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, олон нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Хууль эрх зүйн хэлтэс (Г.Ганзориг)-т тус тус даалгасугай.

5. Эрх бүхий аж ахуй нэгжүүдийн ажиллах цагийн хуваарь болон согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглосон заалтад байнгын хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Баатархүү), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны "Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх, цагийн хуваарийг шинэчлэн тогтоох тухай" А/86 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

М.ИДЭРБАТ

2224010052

2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн
11/19 дүгээр захирамжийн хавсралт

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ
ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРУУДЫН СОГТУУРУУЛАХ УНДАА,
ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ЦАГИЙН ХУВААРЬ**

№	Үйлчилгээний ангилал	Худалдах, үйлчлэх үйлчилгээний ангилал	Үйл ажиллагаа явуулах цагийн хязгаар
Худалдах тусгай зөвшөөрөл эзэмших			
1	Их дэлгүүр	Худалдахыг зөвшөөрнө	07:00-00:00
2	Хайпермаркет		
3	Супермаркет		
4	Минимаркет		
5	Хүнсний дэлгүүр		
6	Ая тухтай дэлгүүр		
7	Бөөний худалдааны төв	Худалдахыг зөвшөөрнө	07:00-22:00
8	Үйлдвэрийн нэрийн барааны дэлгүүр		
9	Агуулах дэлгүүр		
10	Бөөний төв		
Үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч			
1	Ресторан	Үйлчлэхийг зөвшөөрнө	14:00-04:00 эсвэл 11:00-22:00 Аж ахуй нэгжийн сонголтоор
2	Баар, паб, лоунж, караоке, диско клуб, тайчих клуб		
3	Эвент танхимын үйлчилгээ		
4	Улирлын чанартай, түр сүүдрэвчтэй үйлчилгээ		
5	Жуулчны бааз, амралтын газрын дэргэдэх ресторан, баар, кафе		
6	Баар (биллиард, спорт)	Үйлчлэхийг зөвшөөрнө	11:00-22:00
7	Кафе		

